

# Цалин болон орлого, инфляци хоорондын уялдаа

*Мөнгөний Бодлогын Хэлтсийн эдийн засагч*

*Д. Ган-Очир*

## **ХУРААНГУЙ**

Төрийн албан хаагчдын цалин өсөх<sup>1</sup> (өрхийн цалин болон орлого<sup>2</sup> нэмэгдэх) нь инфляцийг өсгөх шалтгаан болдог уу, эсрэгээр нь инфляци өндөр байх нь цалин болон орлогыг өсгөх шаардлага бий болгож байна уу гэсэн асуултуудын хариулт нь маргаантай байсаар байгаа бөгөөд үүний хариултыг эмпирик байдлаар шалган тодорхойлох нь чухал байна. Энэ үүднээс энэхүү судалгааны ажлаар цалин болон орлого, инфляци хоорондын уялдааг 1993 оны 1 дүгээр улирлаас 2005 оны 4 дүгээр улирлын хоорондын тоон өгөгдлийг ашиглан эконометрикийн коинтэгрэшин болон алдаа залруулах загварын үр дүнд суурилсан Гранжер шалтгааны шинжилгээгээр судаллаа. Ийнхүү судлахдаа бид энэ төрлийн судалгаануудад өргөн ашиглагддаг Gordon (1982, 1985)-ны анх ашигласан инфляцийн процессын онолын суурь загвар болох хүлээлт агуулсан дэвшилтэт Филлипсийн муруйн эконометрик загварыг ашиглалаа.

## **I. ТАНИЛЦУУЛГА**

Төрийн албан хаагчдын цалин өсөх нь боловсон хүчний шилжилтийн болгоомжлол, инфляцийн бага зэргийн өсөлтөөр дамжин хувийн хэвшилд ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх шалтгаан болох бөгөөд энэ тохиолдолд нийт өрхийн цалин болон орлогын өсөлт нь нийт эрэлтийг өсгөн улмаар илүү өндөр инфляцийн шалтгаан (demand driven inflation)-ыг бий болгох талтай. Энэхүү нөлөөлөл нь тодорхой хугацааны хоцролттойгоор илэрдэг гэж үздэг. Гэхдээ энэхүү цалингийн өсөлт нь тус сувгаар инфляцид нөлөөлнө, нөлөөлөхгүй гэсэн байр суурь маргаантай байсаар байгаа бөгөөд үүнд хариулт өгсөн эмпирик судалгаа өмнө нь манай оронд хийгдээгүй байна. Иймд эдгээрийн хариултыг эмпирик шинжилгээний үр дүнд суурилан олох нь чухал. Мөн цалин, орлогын өсөлт нь энэхүү өсөлтөөсөө илүүтэй инфляцийг бий болгох, мөн нийт иргэдийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж болдог.<sup>3</sup> Энэ тохиолдолд цалинг инфляцийг хэт өсгөх шалтгаан болгохгүйгээр хэдэн хувиар өсгөх боломжтой байгаа, эсрэгээр нь бусад хүчин зүйлсийн

---

<sup>1</sup> Төрийн албан хаагчдын цалин нь нийт эдийн засаг дахь цалингийн өсөлтийг бий болгох боломжтой, ийнхүү шууд нөлөө үзүүлдэггүй гэвэл эдийн засагт өрхийн дундаж цалингийн болон нийт орлогод энэхүү нөлөөлөл нь илэрнэ гэж үзнэ. Учир нь 2002-2005 онуудын хооронд нийт ажилтай хүмүүсийн 12,7-15,6 % нь төсөвт байгууллагад ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд төсвийн байгууллагад ажиллагсдын цалин жилд дунджаар 19,8 хувиар өсч байсан.

<sup>2</sup> Эдгээр өгөгдлийг тооцохдоо YCG-аас улирал тутам явуулдаг өрхийн орлого, зарлагын судалгааны 1993-2005 оны хоорондын тоон мэдээллийг ашиглалаа.

<sup>3</sup> Манай орны хувьд төрийн албан хаагчдын бодит цалингийн өсөлт нь эерэг байсан хэдий ч хэрвээ инфляцийн шалтгаан болж байгаа нь л бол бүхий л нийгэмдээ сөрөг үр дагаврыг бий болгоно. Учир нь төрийн албан хаагчдын бодит худалдан авах чадвар нэмэгдэх боловч бусад орлого доогуур өрхүүдийн хувьд орлогын өсөлтгүйгээр харин ч цалингийн өсөлтөөс улбаатай инфляцийн нэмэлт дарамтыг хүлээж авахад хүрнэ.

нөлөөгөөр бий болсон өндөр инфляци нь өрхийн цалин болон орлогыг өсгөх шалтгаан болж байна уу зэргийг тодорхойлох, үр дүнг бодлогын шийдвэрт ашиглах нь ач холбогдолтой юм.

Цалин, инфляци хоорондын уялдааг тодорхойлох онол, эконометрик загварыг анх Gordon (1982, 1985) өөрийн судалгаандаа харуулсан байдаг бөгөөд тухайн загварыг Stokton болон Glassman (1987), Mehra (1991, 1993, 2000), Ghalli (1999) болон Emery болон Chang (1995) нар өөрсдийн ажилдаа тайлбарлагч хувьсагчдыг өөрчлөн өргөтгөж эконометрик шинжилгээнүүдийг хийсэн байдаг. Харин бид өөрсдийн судалгаандаа Mehra (1991, 1993, 2000) болон Zenetti (2005)-ын өөрийн ажилдаа өргөтгөн ашигласан инфляцийн процессын онолын суурь загвар болох хүлээлт агуулсан дэвшилтэт Филлипсийн муруйн эконометрик загвар, аргачлалыг суурь болгон ашигласан болно.

Энэхүү судалгааны зорилго нь Монголын эдийн засаг дахь цалин, орлого болон инфляци нь харилцан бие биенийхээ шалтгаан болдог эсэхийг эмпирик байдлаар шалгах, урт болон богино хугацааны харилцан нөлөөллийн мэдрэмжийг тодорхойлоход оршино.

Судалгааны ажил нь дараахь бүтэцтэй: 2 дахь хэсэгт Монголын өрхийн цалин болон орлого, инфляцийн динамик хандлага, динамик өөрчлөлтийн учир шалтгааныг тайлбарласан. 3 дугаар хэсэгт тухайн судалгаанд ашигласан онолын болон эконометрик загварыг танилцуулсан. 4 дүгээр хэсэгт тус судалгааны түүвэр, тоон үзүүлэлтүүдийн тайлбар болон загварт тодорхойлогдсон хувьсагчдад ямар хувьсагчдыг сонгосон талаар дурьдсан. Мөн эконометрик загварын үнэлгээ, чухал үр дүнгүүдийн тайлбарыг хийсэн. 5 дугаар хэсэгт судалгааны үр дүн, дүгнэлтүүдийг нэгтгэсэн.


## **II. ЦАЛИН БОЛОН ОРЛОГО, ИНФЛЯЦИЙН ДИНАМИК ХАНДЛАГА, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙН УЧИР ШАЛТГААН**

Цалин болон орлого, инфляцийн хоорондын уялдааг судлах энэхүү судалгаа нь манай орны хувьд энэ төрлийн анхдагч судалгааны ажил юм. Цалин орлогын тухай тоон өгөгдлийн найдвартай статистик тоо байхгүй, ямар үзүүлэлтүүдийг сонгон ашиглаж болох тухай мэдээлэл хомс юм. Иймээс судалгаандаа манай орны хувьд цалин болон орлогын хамгийн урт цуваа үүсгэж, эконометрик шинжилгээ хийх боломжийг бий болгож байгааг үндэслэн ҮСГ-аас улирал тутам явуулдаг “Өрхийн орлого, зарлагын түүвэр судалгаа”-ны үр дүнгийн нэгтгэлд гардаг өрхийн нийт болон цалингийн орлогын тоон үзүүлэлтүүдийг авч ашиглалаа. Мөн төрийн албан хаагчдын дундаж цалингийн талаарх мэдээллийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас авч ашигласан.

Иргэдийн дунд төсөвт байгууллагад ажиллагсдын цалингийн өсөлт нь үнийн өсөлтөө давж, бодит худалдан авах чадварыг нэмэгдэхгүй байгаа тухай яриа их байдаг. Тэгвэл статистик мэдээлэлд бүртгэгдсэнээр энэ байдал ямар байдалтай байгааг авч үзэхдээ бодит цалин (нэрлэсэн цалин, ХҮИ-ийн харьцаа)-аар хэмждэг, үүнээс гадна эдгээрийн өсөлтийн хурдыг харьцуулах замаар тодорхойлж болно. Судалгаандаа эдгээр аргуудыг ашиглан дүгнэлт гаргахыг зорилоо. Иймд Зураг 1-т төсөвт байгууллагад ажиллагсдын дундаж цалин, түүний жилийн өсөлт болон инфляцийг үзүүллээ. Төсөвт байгууллагад ажиллагсдын жигнэсэн дундаж цалинг тооцохдоо салбаруудын дундаж цалинг тус салбарт ажиллагсдын тоогоор жигнэж гаргасан бөгөөд ажиллагсдын тоон мэдээллийг Хавсралт 1-д харууллаа. Хавсралт 1-ээс харахад төсөвт байгууллагад ажиллагсдын нийт тоо сүүлийн

жилүүдэд буурч байгаа бөгөөд энэ нь амралт, соёл урлаг, нийгмийн даатгал, халамж, эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсдын тоо буурч буйтай холбоотой байна.

**Зураг 1. Төсөвт байгууллагад ажиллагсдын жигнэсэн дундаж цалин, түүний өсөлт**



Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Монголбанк

Зураг 1-ээс харахад төсөвт байгууллагад ажиллагсдын жигнэсэн дундаж цалин сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн хандлагатай байна. Харин цалингийн өсөлт нь жил бүр харилцан адилгүй, тогтвортой бус хувиар өссөн буюу 1996, 2000, 2002, 2006 онуудад цалингийн өндөр өсөлт ажиглагдаж, харин бусад жилүүдэд өмнөх оны өсөлтөөс доогуур байсан байна.


Ийнхүү цалин тогтвортой бус хувиар өссөн нь цалин, инфляци хоорондын уялдаатай холбоотой байж болох буюу инфляци өндөр гарсан жилүүдэд цалин илүү хувиар өсөх (мөн эсрэгээр нь цалин өндөр хувиар өссөн нь инфляцийн шалтгаан болсон), инфляци бага гарсан жилүүдэд цалин бага хувиар өссөн (мөн эсрэгээр нь цалин бага хувиар өссөн нь инфляцийг хөөрөгдөөгүй)-тэй холбоотой байж болно.

Зураг 1-ээс харахад цалин болон инфляци нь адил чиглэлтэй байгаа буюу өндөр инфляцитай жилд цалин өндөр хувиар, доогуур инфляцитай жилд цалин доогуур хувиар өссөн хандлага ажиглагдаж байна. Гэхдээ эндээс бид шууд инфляци болон цалингийн аль алиныхаа шалтгаан болсныг шууд хэлэх боломжгүй бөгөөд үүний хариултыг Гранжер шалтгааны тестийн үр дүнгээс олох боломжтой.

1995-1997 оны өндөр инфляцитай жилүүдэд цалингийн өсөлт өндөр байсан хэдий ч бодит цалин төдийлөн өсөөгүй буюу ердөө 1.9-5.9 хувиар өссөн байна. Харин 1998- 2000 оны хооронд цалингийн өсөлт нь инфляциас өндөр буюу бодит цалин 4.5-25.1 хувиар өссөн, харин 2001 онд цалингийн өсөлт нь инфляциас доогуур буюу бодит цалин өмнөх оноос 5.8 хувиар буурчээ. 2002-2004 онуудад цалингийн өсөлт нь инфляциас илүүгээр өссөн буюу бодит цалин 4.5-22.0 хувиар өссөн бол 2005-2006 онуудад бодит цалин 2.5-23.2 хувиар өссөн байна.

Цалингийн өсөлт нь 2001 оноос бусад жилүүдэд инфляциас өндөр байсан буюу бодит цалин (худалдан авах чадвар)-г өсгөж чадаж байсан байна. Мөн бодит цалин 2000 онд 25.1 хувиар, 2006 оны II дугаар улирлын байдлаар 26.3 хувиар өссөн нь бусад онуудын өсөлтөөс хамгийн өндөр нь байна. Харин төсөвт байгууллагад ажиллагсдын цалингийн түвшинг салбараар нь Хүснэгт 1-т харуулсан бол цалингийн өсөлтийн хувийг Зураг 3 болон Зураг 4-т харууллаа.


**Зураг 3. Төсөвт байгууллага (нийтийн ерөнхий үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдал, боловсрол)-д ажиллагсдын дундаж цалингийн өсөлтийн хувь хэмжээ**



Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам

Зураг 3-ын хувьд эдгээр 3-н салбарын цалингийн өсөлтийн хувьд 1996-2002 оны хооронд ойролцоо байсан бол нийгмийн хэв журам, аюулгүй байдлын салбарт ажиллагсдын цалин 2002-2004 оны хооронд харьцангуй савалгаатайгаар өссөн байна. Эдгээр салбарын цалингийн өсөлт нь 2001, 2003 (зөвхөн нийгмийн хэв журам, аюулгүй байдал) 2005 онуудаас бусад жилд инфляцийн түвшингээс өндөр байжээ.

**Зураг 4. Төсөвт байгууллага (Эрүүл мэнд, амралт, соёл урлаг, ХАА, ойн аж ахуй)-д ажиллагсдын дундаж цалингийн өсөлт**



Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам

Төсөвт байгууллагад ажиллагсдын цалингийн өсөлт нь салбаруудын хувьд ерөнхийдөө адил динамиктай байна. Энэ нь төсөвт байгууллагын цалин өсгөх шийдвэр нь нийгмийн хамарсан агуулгатай бөгөөд харин өсөлтийн хувь нь харилцан ялгаатай байгаа нь салбарын өөрийнх нь онцлогтой холбоотой.

Зураг 4-ын хувьд эдгээр салбаруудын цалингийн өсөлтийн динамик хандлага нь адил байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарын дундаж цалингийн өсөлт тогтмол эерэг байхад харин амралт, соёл урлаг, ХАА, Ойн аж ахуйн салбарт ажиллагсдын дундаж цалин зарим жилүүдэд өмнөх жилүүдээс бууралттай байжээ. ХАА-н салбарын цалингийн өсөлт нь 1996, 1999, 2001, 2003 онуудад инфляцийн түвшингээс доогуур байсан бол амралт, соёл урлагийн салбарын цалингийн өсөлт нь 1998, 2001, 2005 онуудад инфляцийн түвшингээс доогуур байна. Харин эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын цалин 1999, 2001, 2005 онуудад инфляцийн түвшингээс доогуур байсан бөгөөд эдгээр бүх салбарын цалингийн өсөлт нь нийт жигнэсэн дундаж цалингийн өсөлтийн динамик хандлагатай далайцын хувьд ялгаатай хэдий ч мөчлөгийн хувьд адил байна.

**Хүснэгт 1. Төсөвт байгууллагад ажиллагсдын дундаж цалин, 1995-2006\* он**


	Нийтийн ерөнхий үйлчилгээ	Нийгмийн хэв журам, аюулгүй байдал	Боловсрол	Эрүүл мэнд	Нийгмийн даатгал, нийгмийн халамж	Амралт, соёл урлаг	ХАА, Ойн аж ахуй	Бусад	Нийт жигнэсэн дундаж цалин
<b>1995</b>	21877.3	14718.4	13963.9	12345.7	20938.0	13246.4	15667.3	16608.1	14719.2
<b>1996</b>	29827.1	24144.09	22524.3	18565.3	37503.8	17291.6	19041.2	17620.4	21562.1
<b>1997</b>	31685.7	29736.5	29358.7	27201.2	31426.8	29086.7	31902.9	16692.7	27262.5
<b>1998</b>	44795.4	38347.0	36097.3	29729.96	33948.7	27747.0	35137.0	28979.2	34488.0
<b>1999</b>	52044.0	43586.9	43173	32328.9	36200.1	35169.9	36362.4	30863.7	39493.0
<b>2000</b>	68861.5	61012.8	56211.7	44268.8	47582.5	42938.7	45826.8	41508.0	52592.5
<b>2001</b>	66825.1	63004.9	57596.6	46090.0	18246.2	43530.9	36369.7	44478.6	53671.9
<b>2002</b>	77290.8	92658.3	67722.4	52315.8	45443.9	57747.3	55426.2	61125.3	66398.0
<b>2003</b>	89404.0	81324.8	79769.2	59096.8	51415.7	60995.3	53390.8	59782.5	72524.8
<b>2004</b>	111610	112824.3	88200	82769.3	72971.7	78676.6	66603.8	70577.5	88374.3
<b>2005</b>	119713.3	112824.5	91211.7	88682.8	89879.3	83061.3	79678.1	116978.4	99893.5
<b>2006.Q2</b>	163407.0	156097.7	122278.8	127574.7	103610.4	109792.1	112575	119552.3	130836.2

\*- 2006 оны хувьд 2 дугаар улирлын байдлаар авсан болно.

Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам


Зураг 5 болон Зураг 6-д харгалзан цалингийн өсөлт, инфляци болон орлогын өсөлт, инфляцийн динамик хандлагыг харьцуулан харууллаа. Зураг 6-аас цалингийн жилийн өсөлт, жилийн инфляцийн ерөнхий динамик хандлага нь адил буюу эдгээрийн хооронд эерэг хамаарал байгаа нь харагдаж байна. Мөн цалингийн өсөлт нь инфляциас илүүтэй савалгаатай байгаа бөгөөд цалингийн өсөлтийн хувьд 1997-1998, 2000-2001, 2003-2004 онуудад мөчлөг ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь хугацааны хоцрогдолтойгоор инфляцийн бага зэргийн мөчлөг ажиглагдахад нөлөөлж байж магадгүй байна (Зураг 5). Манай орны цалингийн огцом өсөлтүүд нь салбарын өсөлт, хөдөлмөрийн бүтээмж зэрэг үзүүлэлтүүдээс илүүтэй бодит худалдан авах чадварыг дээшлүүлэх гэсэн зорилгын дор төрийн байгууллагад ажиллагсдын цалинг зарим жилүүдэд огцом өсгөдөгтэй холбоотой юм.

**Зураг 5. Өрхийн дундаж цалингийн орлогын өөрчлөлт, инфляци, 1993-2005 он**



Зураг 6-аас харахад өрхийн орлогын жилийн өсөлт, инфляци нь ерөнхийдөө адил буурах хандлагатай буюу эдгээрийн хооронд мөн эерэг хамаарал байж болохыг харуулж байна. Мөн өрхийн орлогын өсөлтөнд 2000-2001, 2002-2003 онуудад мөчлөг ажиглагдаж байна. Энэхүү өсөлт буюу мөчлөг нь цалингийн орлогын өсөлт, мөчлөгтэй үндсэндээ давхцаж байна. Харин 2003-2005 оны хооронд өрхийн орлогын жилийн өсөлт, жилийн инфляцийн динамик нь давхцаж буй нь сонирхолтой бөгөөд тус хугацаан дахь мэдрэмж нь 1-д ойрхон байхаар байна.


**Зураг 6. Өрхийн орлогын жилийн өөрчлөлт, жилийн инфляци, 1993-2005 он**



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн газар, “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-наас гарсан тоон үзүүлэлт

Цалин болон орлого, инфляцийн тренд нь адил байгаагаас гадна эдгээр үзүүлэлтүүдэд улирлын хэлбэлзэл, мөчлөг илэрдэг үү, хэрэв илэрдэг бол эдгээр нь хоорондоо давхцдаг эсэхийг тодруулах үүднээс улирлын хэлбэлзлийн индексийг CENSUS X-12 –ыг ашиглан тооцсон бол мөчлөгийг Baxter- King-ийн аргаар (хугацааны хоцрогдлыг 4-өөр сонгон) тооцсон.

**Зураг 7. Улирлын хэлбэлзлийн индекс**




Зураг 7 –д харуулсан улирлын хэлбэлзлийн индексээс харахад жилийн инфляци болон өрхийн орлогын жилийн өсөлт адилхан 1, 2 дугаар улиралдаа ерөнхийдөө улирлын нөлөөллөөр тренд утгаасаа буурах хандлагатай байдаг бол харин 3, 4 дүгээр улиралд өсдөг байна. Гэхдээ өрхийн орлого нь 4 дүгээр улиралдаа улирлын нөлөөллийн хамгийн өндөр түвшиндээ хүрдэг бол, инфляци нь 3 дугаар улиралд өндөр түвшиндээ хүрч, оны сүүл рүү харьцангуй буурч тренд утга орчимдоо байдаг байна. Энэ нь манай орны эдийн засаг улирлын нөлөөлөл ихтэй байдагтай холбоотой юм. Эдгээрийн улирлын нөлөөллөөс үүдэлтэй өсөлт, бууралт нь эхний 3 улиралдаа улиралдаа багтан харилцан



бие биенийхээ шалтгаан болдог байж болох юм. Учир нь эдгээрийн улирлын индексийн чиглэл эхний 3 улиралдаа давхцаж байна.

### Зураг 8. Мөчлөгийн динамик хандлага



Өрхийн орлогод 1994-2004 оны хооронд тогтвортой мөчлөг ажиглагдсан бөгөөд эдгээрийн мөчлөг нь давхцаж байна. Мөчлөгийн хувьд өрхийн орлогын мөчлөгийн далайц нь зарлагын далайцаас илүү өндөр байгаа нь өрхийн дундаж хэрэглээний өсөлт нь харьцангуй тогтвортой байхад орлогын өсөлт нь хэлбэлзэлтэй байдагтай холбоотой байж болох юм. Харин өрхийн орлогын жилийн өсөлт, инфляцийн мөчлөг нь ялгаатай хандлагатай байна (Зураг 8).

## III. ОНОЛЫН ХЭСЭГ

### 3.1 Цалин болон орлого, инфляцийн уялдааг тодорхойлох загваруудын талаар

Инфляци болон цалинг тодорхойлох загваруудын эмпирик шинжилгээг "Үнэ болон цалин тогтох загвар (Price and wage setting price model)", "Макро эконометрик загвар" болон "Филлипсийн муруйн загвар"-уудыг ашиглан хийдэг. Цалингийн үйл хөдлөлийн дээрх загварын ангилалыг өөрөөр Филлипсийн муруйн загвар болон цалингийн муруйн загвар гэж зарим судалгаануудад ангилан дурьдсан байдаг.

Филлипсийн муруйн хандлага нь цалингийн өөрчлөлтийн түвшин болон ажилгүйдлийн түвшин хоорондын сөрөг хамаарал дээр суурилдаг бол, цалингийн муруй нь бодит цалин болон ажилгүйдлийн түвшин хоорондын сөрөг хамаарал дээр суурилдаг. Эдгээр загваруудын үндсэн тавил болон судалгаанд ашиглагдаж байсан байдлыг судлан үзэж, эдгээрээс өөрийн орны хувьд ашиглах боломжтой загварыг сонгох нь тохиромжтой гэж үзлээ. Иймд энэ төрлийн судалгаанд өргөн ашиглагддаг эконометрик загварын тавил, загварт тодорхойлогдсон хувьсагчдад ямар тоон үзүүлэлтүүдийг ашигладаг талаар авч үзье.

Үнэ болон цалингийн загвар дахь үнэ, цалингийн тэгшитгэлүүдийг Layard болон бусад (1991); Несq болон Many (1997); Richardson болон бусад (2000) нар өөрсдийн судалгаандаа дараахь байдлаар тодорхойлон судалсан:

$$p_t - w_t = \alpha_0 + \alpha_1 x_{1t} + \varepsilon_{1t} \quad (1)$$

$$w_t - p_t = \beta_0 + \beta_1 x_{1t} + \beta_2 x_{2t} + \beta_3 x_{3t} + \varepsilon_{2t} \quad (2)$$

Энд бүх хувьсагчид нь натурал логарифм авсан,  $p_t$  - Үнийн түвшин,  $w_t$  - Нэрлэсэн цалингийн түвшин,  $x_{1t}$  - Үнэ болон цалин тогтоход аль алинд нь нөлөөтэй хувьсагчид,  $x_{2t}$  - Цалингийн түвшинд нөлөөлөгч хувьсагчид,  $x_{3t}$  - Үндэслэлтэй (хөдөлмөрийн бүтээмж дээр суурилан тогтоож буй цалин) болон зорьж байгаа (ажиллагсдын авахыг хүсч буй цалин) бодит цалингийн хоорондын цалингийн зөрүүг илэрхийлсэн хувьсагч,  $\varepsilon_{1t}$ ,  $\varepsilon_{2t}$  - Харгалзан үнэ болон цалингийн тэгшитгэлийн алдаа.

(1) буюу үнийн тэгшитгэл нь пүүсийн нийт хөдөлмөрийн эрэлтийн функцыг пүүсийн ашгийн функцэд орлуулан, тэндээс ашиг хамгийн их байх нөхцлөөс гарч ирэх оновчтой үнийн тэгшитгэл байна ( $x_1$  - Ажилгүйдлийн түвшин болон хөдөлмөрийн бүтээмж). (2) буюу цалингийн тэгшитгэл нь хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн функцыг илэрхийлдэг ( $x_1$  - Ажилгүйдлийн түвшин болон хөдөлмөрийн бүтээмж,  $x_2$  - Хуримтлагдсан ашиг, өрсөлдөөний индекс, урт хугацааны ажилгүйдлийн түвшин,  $x_3$  - Татвар болон үнийн хүчин зүйлс (tax wedge and price wedge)).

Макро эконометрик загвар дахь үнэ болон цалингийн тэгшитгэлүүдийг Fair (1984, 1994, 2000) болон Pallis болон бусад (2000) өөрсдийн судалгаандаа дараахь хэлбэртэйгээр судалсан:

$$p_t = \alpha_0 + \alpha_1 p_{t-1} + \alpha_2 w_t + \alpha_3 x_{1t} + \alpha_4 x_{2p,t} + \varepsilon_{1t} \quad (3)$$

$$w_t = \beta_0 + \beta_1 w_{t-1} + \beta_2 p_t + \beta_3 x_{1t} + \beta_4 x_{3w,t} + \varepsilon_{2t} \quad (4)$$

Энд бүх хувьсагчид нь натурал логарифм авсан бөгөөд  $p_t$  - Үнийн түвшин,  $w_t$  - Нэрлэсэн цалингийн түвшин,  $x_{1t}$  - Эрэлтийн талын хувьсагчид,  $x_{2t}$  - Зардлын шокын хувьсагчид,  $x_{3t}$  - Цалингийн шокын хувьсагчид болон  $\varepsilon_{1t}$ ,  $\varepsilon_{2t}$  - Үнэ болон цалингийн тэгшитгэлийн алдаа.

(3) буюу үнийн тэгшитгэл, үнийн түвшин ( $p_t$ )-нд цалин ( $w_t$ ) болон үнийн түвшний хугацааны хоцрогдол ( $p_{t-1}$ , энэ нь хүлээлтийн нөлөөллийг илэрхийлнэ), эрэлтийн талын хувьсагчид ( $x_{1t}$ , ажилгүйдлийн түвшин) болон зардлын шокийн хувьсагчид ( $x_{2p}$  - импортын барааны үнийн индекс) нөлөөлдөг гэж үзсэн. Харин цалингийн (4) тэгшитгэлд үнийн түвшин ( $p_t$ ) болон цалингийн хугацааны хоцрогдол ( $w_{t-1}$ , энэ хүлээлтийн нөлөөллийг илэрхийлнэ), эрэлтийн хүчин зүйлс ( $x_{1t}$ , ажилгүйдлийн түвшин) болон цалингийн шокын хувьсагчид ( $x_{3w}$ , хөдөлмөрийн бүтээмж) нөлөөлдөг гэж үзсэн.

Филлипсийн муруйн загвар дахь үнэ болон цалингийн тэгшитгэлүүдийг Gordon (1982, 1985), Stockton болон Glassman (1987), Ghalli (1999) болон Mehra (1991, 1993, 2000) нарын ажлуудад дараахь байдлаар тодорхойлон загварчилсан байдаг.

$$\Delta p_t = \alpha_p + \beta_{1p} \Delta(w - q)_t + \beta_{2p} d_t + \beta_{3p} z_{pt} \quad (5)$$

$$\Delta(w - q)_t = \alpha_w + \beta_{1w} \Delta p_t^e + \beta_{2w} d_t + \beta_{3w} z_{wt} \quad (6)$$

$$\Delta p_t^e = \sum_{i=1}^n \lambda_i \Delta p_{t-i} \quad (7)$$

Энд бүх хувьсагчид нь натурал логарифм авсан.  $p_t$  - үнийн түвшин,  $w_t$  - нэрлэсэн цалин,  $q_t$  - хөдөлмөрийн бүтээмж,  $d_t$  - нийт эрэлтийн төлөв байдлыг илэрхийлэх хувьсагч,  $z_{pt}$  - үнэд нөлөөлөх нийлүүлэлтийн талын шокууд, мөн  $z_{wt}$  - цалинд нөлөөлөх нийлүүлэлтийн талын шокуудыг илэрхийлнэ.  $\Delta$  - Нэгдүгээр эрэмбийн ялгаврын оператор,  $\Delta p_t^e$  - хүлээгдэж буй инфляцийг илэрхийлнэ.

(5)-(7) тэгшитгэлүүд нь Оукены хууль, Филлипсийн муруй, Хөдөлмөрийн нийлүүлэлтийн муруй тэгшитгэлийн системээр тодорхойлогдоно. (5) буюу үнийн тэгшитгэл, үнэ нь бүтээмжээр зохицуулагдсан хөдөлмөрийн зардал ( $w-q$ ), эрэлтийн хүчин зүйлсийн нөлөө ( $d_t$  - бодит ДНБ болон потенциал ДНБ-ний хоорондын зөрүү болон ажилгүйдлийн түвшин) болон үнийн түвшинд нөлөөлөгч экзоген шокууд ( $z_{pt}$  - импортын барааны үнэ)-аас хамаарч байна. Энэхүү тэгшитгэл нь өгөгдсөн эрэлтийн түвшинд, үнийн түвшин нь бүтээмжээр зохицуулагдсан цалингаар тодорхойлогдож байна.

Харин (6) буюу цалингийн тэгшитгэл нь мөчлөгийн эрэлтийн функц ( $d_t$ ), хүлээгдэж буй үнэ ( $P^e$  - (3) тэгшитгэлд тодорхойлогдсон өмнөх үеүүдийн үнийн түвшнээс хүлээгдэж буй үнэ) болон нийлүүлэлтийн шокоос хамаарна гэж таамагласан.

Эдийн засгийн онолын хувьд цалин болон үнийн хоорондын харилцан шалтгааны механизмыг харуулсан цэвэр тогтсон хандлага байдаггүй хэдий ч энэ сэдвийн хүрээнд эмпирик судалгаанууд түгээмэл хийгдсэн байдаг. Gordon (1988) болон Mehra (1991) нар цалингийн өөрчлөлт нь инфляци (ДНБ-ний дефлятор)-ийг тайлбарлахад нөлөөгүй байна гэж дүгнэсэн. Харин үнийн өөрчлөлт нь цалингийн өөрчлөлтийн Гранжер шалтгаан болж байгааг харуулсан байдаг. Mehra (1993) урт хугацаанд нэгж хөдөлмөрийн зардал болон ХҮИ-ийн хооронд урт хугацааны хамаарал оршин байдаг болон урт хугацаанд ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци нь нэгж хөдөлмөрийн зардлын өсөлтийн шалтгаан болж байдгийг тодорхойлсон. Mehra (2000) цалингийн өсөлт нь тогтвортой өсөж буй инфляцитай үед л ирээдүйн инфляцийг тааварлахад туслаж болохыг харуулсан. Ghalli (1999) Гранжер шалтгаан нь үндсэндээ цалингаас үнэ гэсэн чиглэлтэй байгааг тогтоосон бол Zanetti (2005) Филлипсийн муруйн үнэлгээгээр цалингийн өсөлт нь ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляцийн Гранжер шалтгаан болж байдгийг харуулсан байна.

### 3.2 Цалин болон орлого, инфляцийн хоорондын уялдааг тодорхойлох

## эконометрик загвар

Энэхүү судалгаандаа Филлипсийн муруйн загварыг суурь болгон ашиглах нь тохиромжтой гэж үзсэн. Учир нь тус загвараар тодорхойлогдож буй инфляци болон цалингийн тэгшитгэлүүдийн тайлбарлагч хувьсагчдын тоон мэдээлэл нь бусад загваруудтай харьцуулахад манай орны хувьд тооцон ашиглах боломжтой байна. Мөн нийлүүлэлтийн талын шок ихтэй, энэхүү шокийн нөлөөг хүчтэй тусган авдаг эдийн засгийн хувьд нийлүүлэлтийн шокийн нөлөөг ялган харуулах боломжтой зэргийг харгалзан хүлээлт агуулсан дэвшилтэт Филлипсийн муруйг ашиглалаа.

Филлипсийн муруйн загвараас тодорхойлогдох үнэ болон цалингийн тэгшитгэлүүдийг Gordon (1982, 1985), Stockton болон Glassman (1987), Mehra (1991, 1993, 2000) болон Zanetti (2005) нарын ажлуудад ашигласантай адилаар сонголоо. Ийнхүү адилаар сонгох нь үнэ болон цалингийн тэгшитгэлүүдэд нийт эрэлт, нийлүүлэлтийн шокийн нөлөөллийг илэрхийлэх хувьсагчид болон үнэ, цалин нь харилцан нөлөө үзүүлж болно гэсэн онолын санааг тэгшитгэлд оруулж ирдэгээрээ онцлог юм. Эдгээр нөлөөллийг тусгасан үнэ болон цалингийн тэгшитгэл нь дараахь байдлаар тодорхойлогддог.

$$\Delta p_t = h_0 + h_1 \Delta w_t + h_2 d_t + h_3 S p_t \quad (8)$$

$$h_1 > 0, \quad h_2 < 0, \quad h_3 > 0$$

$$\Delta w_t = k_0 + k_1 \Delta p_t^e + k_2 d_t + k_{3w} S w_t \quad (9)$$

$$k_1 > 0, \quad k_2 < 0, \quad k_3 > 0$$

$$\Delta p_t^e = \sum_{j=1}^n \lambda_j \Delta p_{t-j} \quad (10)$$

Энд бүх хувьсагчид нь натурал логарифм авсан, эдгээр үзүүлэлтүүдэд судлаачид дараахь хувьсагчдын ашигладаг.

Үнийн түвшин ( $p_t$ ) - Хэрэглээний үнийн индекс (ХҮИ); ДНБ-ний дефлятор;  $\Delta p_t$  - ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци;

Нэрлэсэн цалин ( $w_t$ ) - Нэрлэсэн цалин;

Эрэлтийн хувьсагч ( $d_t$ ) - 1) Бодит болон Потенциаль ДНБ)-ий зөрүү (output gap) эсвэл ажилгүйдлийн түвшин; 2) М1 мөнгөний нийлүүлэлт ;

Нийлүүлэлтийн шок ( $S p_t$ ;  $S w_t$ ) – Импортын барааны үнийн инфляци, манай орны хувьд мах махан бүтээгдэхүүний бүлгийн ХҮИ-ээр төлөөлүүлэн авах боломжтой;

Эдгээр үзүүлэлтийн өмнөх коэффициентүүдэд дараахь урьдчилсан таамаглалыг шалгана. Үүнд:

- Цалингийн өсөлт нь үнийн өсөлтийн тодорхойлогч хүчин зүйл мөн ( $h_1 > 0$ );
- Эрэлтийн талын хүчин зүйл (Бодит ДНБ хасах нь потенциал ДНБ) нь үнийн түвшинд эерэг нөлөө үзүүлнэ ( $h_2 < 0$ );

- Нийлүүлэлтийн талын шок (мах, махан бүтээгдэхүүний ХҮИ) нь үнийн түвшнийг өсгөнө ( $h_3 > 0$ );
- Хүлээгдэж буй үнийн өсөлт нь цалингийн өсөлтийн шалтгаан болно ( $k_1 > 0$ );
- Эрэлтийн талын хүчин зүйл (Бодит ДНБ хасах нь потенциал ДНБ) нь цалингийн түвшинтэй эерэг нөлөөтэй ( $k_2^{gap} > 0$ );
- Эрэлтийн хүчин зүйл (M1 мөнгөний өсөлт) нь үнийн түвшин болон цалингийн түвшинтэй эерэг хамааралтай ( $k_2^{M1} > 0$ );
- Нийлүүлэлтийн талын шок (мах, махан бүтээгдэхүүний ХҮИ) нь цалингийн түвшинг өсгөх шаардлагыг бий болгоно.

Филлипсийн муруйн загвараар тодорхойлогдож байгаа (8)-(10) тэгшитгэлүүд нь үнэ болон цалингийн урт хугацааны хамаарлын тэгшитгэлүүдийг илэрхийлэх бөгөөд өгөгдлийн time series шинж чанараас хамааран энгийн хялбар аргачлал эсвэл коинтегрэйн, алдаа залруулах механизм (ЕСМ) хэлбэрт эконометрик үнэлгээ хийгдэх эсэх нь тодорхойлогдох ёстой. Тус судалгаанд ашиглаж буй тоон үзүүлэлтүүд нь тогтворгүй байгаа тул үнэ болон цалингийн (8) болон (9) тэгшитгэлүүд нь урт хугацааны коинтегрэйн хамааралтай эсэхийг шалган, коинтегрэйн хамаарал оршин байвал сул экзоген тестийг явуулна. Хэрвээ коинтегрэйн хамааралд тодорхойлогдсон бүх хувьсагчидын хувьд сул экзоген тест няцаагдвал эдгээрийн хоорондын Гранжер шалтгааныг шалгах тэгшитгэлийг ЕСМ хэлбэрт үнэлэх шаардлагатай болно. Иймд коинтегрэйн хамаарлыг хэрхэн шалгах болон сул экзоген тест, Гранжер шалтгааныг шалгах ЕСМ -ын тэгшитгэлийг дараагийн хэсэгт авч үзэх болно.

### 3.3 Коинтегрэйн болон Гранжер шалтгааны тест

Цалин болон үнэ хоорондын урт хугацааны хамаарлыг Johansen болон Juselius (1990) нарын гаргасан коинтегрэйн шалгах тестийг ашиглан шалгах болно. Энэхүү тестийн процедур буюу JJ процедур нь энгийн түвшиндээ (level) тогтворгүй time series өгөгдлүүдийн VAR загварын үнэлгээтэй адил байна. Үзүүлэлтүүдийн энгийн хэлбэрт үнэлэгдсэн коэффициентийн матриц нь тус загварын урт хугацааны шинж чанарын тухай мэдээллийг агуулна гэж үздэг.

Загварыг тайлбарлавал,  $X_t$  нь үнэ болон цалин, бусад нөлөөлөгч time series үзүүлэлтүүдийг агуулсан вектор хувьсагч байна. Вектор авторегрессив (VAR) загвар нь:

$$X_t = \Pi_1 X_{t-1} + \Pi_2 X_{t-2} + \dots + \Pi_k X_{t-k} + \varepsilon_t, \quad (11)$$

Энд  $X_t$  - тогтворгүй (жишээ нь I(1)) n- вектор хувьсагчид,  $\Pi_i$ ,  $i=1, \dots, k$ , нь  $X_{t-i}$  -ийн өмнөх коэффициентүүдийн матриц,  $\varepsilon_t$  - тэгшитгэлийн үлдэгдлийн вектор,  $X_t$  time series нь 1-р эрэмбийн ялгаврын дараа тогтвортой гэж таамаглавал (11) хэлбэрийг тэгшитгэлийг өөрчлөх буюу тэгшитгэлийн 2 талын гишүүн бүрээс нэг хугацааны хоцролттой хувьсагчдыг хасч, ялгавар авсан болон аваагүй гэсэн 2 хэлбэрийн нийлбэр хэлбэрт шилжүүлэн бичиж болно. Энэхүү өөрчлөлтийг тэгшитгэл (12)-г харууллаа.

$$\Delta X_t = \Gamma_1 \Delta X_{t-1} + \dots + \Gamma_{k-1} \Delta X_{t-k+1} + \Pi X_{t-k} + \varepsilon_t, \quad (12)$$

Энд:  $\Gamma_i = -\sum_{j=i+1}^k \Pi_j$ ,  $i = 1, \dots, k-1$ , болон  $\Pi = \sum_{i=1}^k \Pi_i - I$  нь харгалзан нэгдүгээр эрэмбийн ялгавар авсан болон энгийн хэлбэрийн  $X_t$ -ийн өмнөх коэффициентийн матриц. (12) тэгшитгэлийн  $\Pi X_{t-k}$  хэсэг нь  $X_t$ -ийн энгийн хэлбэрийн урт хугацааны шугаман хамаарал байна. Мөн  $\Pi$  матриц нь загварын урт хугацааны шинж чанарын талаарх мэдээллийг агуулсан коэффициентүүдийн матриц байна. Хэрвээ  $\Pi$  матрицын ранг<sup>4</sup> нь тэгтэй тэнцүү байвал (12) тэгшитгэл нь нэгдүгээр эрэмбийн ялгавар авсан богиносгосон (reduced) VAR загвар байна. Энэ нь VAR загварын хувьсагчдын хооронд шугаман урт хугацааны хамаарал оршин байхгүй байгааг харуулна. Нөгөө талаас хэрвээ  $\Pi$  матрицын ранг нь нэгтэй тэнцүү бол  $X_t$  вектор хувьсагчдын хооронд нэг боломжит шугаман хамаарал байгааг харуулах буюу хувьсагчдын хооронд урт хугацааны коинтэгрэшн хамаарал байгааг харуулна. Мөн ранг-ын тоо нь 1-ээс их бол  $X_t$ -ийн элементүүдийн хооронд 1-ээс илүү коинтэгрэшн хамаарал байна.

Хувьсагчдын хоорондын коинтэгрэшн хамаарлыг шалгахдаа Engle, Granger (1986) болон Johansen, Juselius (1990)-ыг аргын ашигладаг. Эхний арга болох Engle, Granger (1987) -ын арга нь хувьсагчдын хоорондын урт хугацааны хамаарлын тэгшитгэлийг үнэлэн үлдэгдлийг ялган авч тогтвортой эсэхийг нь шалгадаг. Хэрвээ тэгшитгэлийн үлдэгдэл нь тогтвортой байвал эдгээр хувьсагчдын хооронд урт хугацааны шугаман коинтэгрэшн хамаарал оршин байна гэж үздэг. Хоёрдахь арга болох Johansen, Juselius (1990)-ын арга нь Коинтэгрэшн хамаарлын тоог тодорхойлохдоо 2 тест статистикийг ашигладаг. Эхнийх нь Trace тест, энэхүү тестээр  $\Pi$  матрицын ранг-ыг шалгадаг бөгөөд ингэхдээ  $rank(\Pi) \leq r$  гэсэн тэг таамаглалыг шалгадаг, энд  $r$  нь коинтэгрэшн векторын тоо бөгөөд  $r = 1, \dots, n-1$  гэж дэс дараалуулан шалгана (Тэг таамаглалыг үл няцаах  $r$ -ийн тоо нь коинтэгрэшн хамаарлын тоо байна). Хоёрдахь нь maximum eigenvalue test, энэхүү тест нь  $r+1$  векторын коинтэгрэшн векторын тоо  $r$  байна гэсэн тэг таамаглалыг шалгадаг. Эдгээр тест статистикийн критик утгыг Johansen болон Juselius (1990)-ын ажлаас харж болно. Энэхүү тестийг Eviwes программ дээр хэрхэн шалгадгийг Н.Ургамалсувд (2002), "Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн уялдаа" ажлаас харах боломжтой.

Granger (1988) хэрвээ 2 өгөгдлийн хооронд коинтэгрэшн хамаарал оршин байвал эдгээрийн хооронд хамгийн багадаа 1 чиглэлд Гранжер шалтгаан байх ёстойг харуулсан байдаг.

Коинтэгрэшн хамаарлыг тодорхойлсны дараа алдаа залруулах загварыг энгийн хэлбэрт үнэлэх үү, систем тэгшитгэлийн хэлбэрт үнэлэх эсэхээ тодорхойлох үүднээс сул экзоген тестийг хийх хэрэгтэй болно. Энэхүү тестийг шалгахын тулд дараах регрессийг үнэлэх шаардлагатай:

$$\Delta p_t = \alpha_p + \beta_p ec_{p,t-1} + \sum_{s=1}^n \delta_{ps} \Delta p_{t-s} + \varepsilon_{pt} \quad (13.1)$$

<sup>4</sup> Матрицын ранг нь тухайн матрицын шугаман бие даасан (independent) багана (эсвэл мөр)-ын тоо байна.

$$\Delta w = \alpha_w + \beta_w ec_{w,t-1} + \sum_{s=1}^n \delta_{ws} \Delta w_{t-s} + \varepsilon_{wt} \quad (13.2)$$

Энд  $ec_p$  болон  $ec_w$  нь харгалзан үнэ болон цалингийн тэгшитгэлийн error correction буюу коинтгэрэшн тэгшитгэлийн үлдэгдэл болно.  $n$  хугацааны хоцролтын оптималь тоог Schwartz шалгуураар тодорхойлно. Эдгээр тэгшитгэлийг тус бүрд нь үнэлэн error correction-ны өмнөх коэффициент нь статистикийн хувьд ач холбогдолтой байвал тус үр дүн нь сул экзоген гэсэн таамаглалыг няцаана, харин статистикийн хувьд ач холбогдолгүй гарвал сул экзоген гэсэн таамаглалыг няцаахгүй. Энд зөвхөн үнэ болон цалингийн тэгшитгэлийн хувьд харуулсан бөгөөд ерөнхий тохиолдолд коинтгэрэшн хамааралд байгаа бүх гишүүний хувьд энэхүү тестийг шалгана. Энэхүү тестийг Eviews программ дээр үнэлэгдсэн вектор хэлбэрт алдаа залруулах загварын ЕС-ны өмнөх коэффициентэд хязгаарлалт тавих байдлаар хялбар шалгах боломжтой тул судалгаандаа энэ аргыг ашиглана.

JJ процедурын дараагийн алхам нь цалин болон үнийн хооронд коинтгэрэшн хамаарал байх бөгөөд энэхүү үнэлэгдсэн Коинтгэрэшн хамаарал нь дараахь байдалтай байна гэж таамагладаг. Үүнд:

$$P_t = \delta w_t + U_{1t}, \quad \delta > 0,$$

Энд  $U_1$  - санамсаргүй алдаа. Энэ нь (12) тэгшитгэлд  $X_t = \{P_t; w_t\}$  гэж үзвэл тус тэгшитгэлийн error correction (ЕС:  $ec_{p,t-1} = P_{t-1} - \delta w_{t-1}$ ,  $ec_{w,t-1} = w_{t-1} - \gamma P_{t-1}$  бөгөөд эдгээрийн хооронд коинтеграци хамаарал олдсон тохиолдолд  $\delta = -\frac{1}{\gamma}$  байна) бөгөөд ЕС-ыг (12) тэгшитгэлд орлуулбал:

$$\Delta P_t = \alpha_p + \sum_{s=1}^{n1} a_{1s} \Delta P_{t-s} + \sum_{s=1}^{n3} a_{2s} \Delta w_{t-s} + \lambda_1 [P_{t-1} - \delta w_{t-1}] + \varepsilon_{pt}, \quad (14.1)$$

$$\Delta w_t = b_w + \sum_{s=1}^{n1} b_{1s} \Delta w_{t-s} + \sum_{s=1}^{n3} b_{2s} \Delta P_{t-s} + \lambda_2 [w_{t-1} - \gamma P_{t-1}] + \varepsilon_{wt}, \quad (14.2)$$

Энд бүх хувьсагчид нь өмнө тодорхойлогдсон бөгөөд  $\lambda_1, \lambda_2 \neq 0$  байна.<sup>5</sup> Тэгшитгэл (14) нь үнэ болон цалингийн урт болон богино хугацааны динамикийг илэрхийлэх бөгөөд үнийн түвшин  $P_{t-1}$  нь урт хугацааны утга  $\delta w_{t-1}$ -ээс зөрөх зөрүү, эсрэгээр нь  $w_{t-1}$  нь урт хугацааны тэнцвэрт утга  $\gamma P_{t-1}$ -ээс зөрөх зөрүү болон урт хугацаан дахь эдгээр 2 хувьсагчийн үнэ эсвэл цалин эсвэл 2-уулангийнх нь зохицуулалтыг илэрхийлж байна. Эдгээр тэгшитгэлүүд нь  $n_1 = n_3 = n$  тохиолдолд коинтгэрэшн хязгаарлалттай VAR загвар буюу Vector Error Correction (VEC (n)) загвар байна. Харин  $n_1 \neq n_3$  тохиолдолд эдгээр

<sup>5</sup> Хэрвээ  $\lambda_1 = \lambda_2 = 0$  гэдэг нь (9) тэгшитгэл дэхь  $\Pi$  матриц нь тэг ранг-тай буюу цалин болон үнийн хооронд урт хугацааны хамаарал байхгүй байгааг илэрхийлнэ.

тэгшитгэлийг дан данд нь үнэлэх болон систем тэгшитгэлийн хэлбэрт боломжит үнэлгээний аргазүйгээр үнэлэх болно. Цалин нь үнийн Гранжер шалтгаан болохгүй байх таамаглалыг шалгах тест нь  $a_{2s} = 0$  (богино хугацаанд) болон  $ec_{t-1}$  -ийн оронд Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг шууд үнэлгээд ашиглаж буй тохиолдолд  $\lambda_1 = 0$  (урт хугацаанд), харин Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг үндсэн тэгшитгэлд орлуулан үнэлгээг хийж буй тохиолдолд  $\delta/\lambda_1 = 0$  (урт хугацаанд) байна гэж шалгана. Харин үнэ нь цалингийн Гранжер шалтгаан болохгүй байх таамаглалыг шалгах тест нь  $b_{2s} = 0$  (богино хугацаанд) болон  $ec_{t-1}$  -ийн оронд Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг шууд үнэлгээд ашиглаж буй тохиолдолд  $\lambda_2 = 0$ , Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг үндсэн тэгшитгэлд орлуулан үнэлгээг хийж буй тохиолдолд  $\gamma/\lambda_2 = 0$  (урт хугацаанд) байна гэж шалгана.

(14.1) болон (14.2) тэгшитгэлүүд нь зөвхөн цалин болон үнэ нь харилцан бие биеэндээ нөлөөлөх энгийн хэлбэрийн Гранжер шалтгааны тестийг шалгах тэгшитгэлүүд юм. Харин үнэ болон цалинд нөлөөлөгч хүчин зүйлсийг тэгшитгэлд бүрэн оруулж коэффициентүүдэд хязгааралт тавих байдлаар эдгээрийн хоорондын Гранжер шалтгааныг шалгах нь илүү бодиттой үр дүн харуулна. Иймд эмпирик шинжилгээнд Гранжер шалтгааны тестийг шалгах тэгшитгэлийг (8) болон (9) тэгшитгэлд тодорхойлогдсон хувьсагчид болон бусад нөлөөлөгч хувьсагчдыг нэмж оруулан ЕСМ хэлбэрт бичвэл:

$$\Delta P = \alpha_p + \sum_{s=1}^{n1} \beta_{1s} \Delta P_{t-s} + \beta_2 ec_{p,t-1} + \sum_{s=1}^{n3} \beta_{3s} \Delta w_{t-s} + \sum_{s=1}^{n4} \beta_{4s} Gap_{t-s} + \sum_{s=1}^{n5} \beta_{5s} \Delta M_1_{t-s} + \sum_{s=1}^{n6} \beta_{6s} \Delta MCPI_{t-s} + \varepsilon_{pt} \quad (15.1)$$

$$\Delta w_t = \mu_w + \sum_{s=1}^{n1} \lambda_{1s} \Delta w_{t-s} + \lambda_2 ec_{w,t-1} + \sum_{s=1}^{n3} \lambda_{3s} \Delta P_{t-s} + \sum_{s=1}^{n4} \lambda_{4s} Gap_{t-s} + \sum_{s=1}^{n5} \lambda_{5s} \Delta M_1_{t-s} + \sum_{s=1}^{n6} \lambda_{6s} \Delta MCPI_{t-s} + \varepsilon_{wt} \quad (15.2)$$

Энд:  $ec_{p,t-1}$  - Үнийн коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдэл,  $ec_{w,t-1}$  - Цалингийн Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдэл Р-Хэрэглээний үнийн индекс, w- нэрлэсэн цалин, Gap- бодит ДНБ болон потенциал ДНБ-ний зөрүү, энэхүү хувьсагч нь бодит эдийн засгийн эрэлтийн талын төлөв байдлыг илэрхийлнэ, M1- M1 мөнгө, энэхүү хувьсагч нь мөнгөний нөлөөллийг илэрхийлнэ, MCPI - Мах, махан бүтээгдэхүүний хэрэглээний үнийн индекс, энэ нь эдийн засаг дахь нийлүүлэлтийн талын шокиг илэрхийлнэ. Учир нь манай орны хувьд нийлүүлэлтийн гол шок нь шатахууны үнийн өсөлт бөгөөд энэ нөлөөллийг богино хугацаанд тусган улмаар эдийн засгийн бусад хүчин зүйлст дамжуулж байгаа хувьсагч нь мах махан бүтээгдэхүүний үнэ байна. Иймд энэ бүлгийн үнийн индекс нь нийлүүлэлтийн шокийн нөлөөллийг төлөөлөх боломжтой гэж үзлээ (Манай орны суурь инфляцийн тооцоонд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн ХҮИ (үүнээс гадна ногоо, сүүний бүлгийн индексийг хасдаг) хасагдаж тооцогддог).



Эдгээр тэгшитгэлүүд нь (14.1; 14.2) -тай адилаар  $n_1 = n_3 = n_4 = n_5 = n_6 = n$  тохиолдолд  $VEC(n)$  загвар болох бөгөөд энэ нөхцөл биелэхгүй тохиолдолд (15.1; 15.2) тэгшитгэлүүдийг дан данд нь үнэлэх болон систем тэгшитгэлийн тохиромжтой үнэлгээний аргаар үнэлэх юм. Цалин нь үнийн Гранжер шалтгаан болохгүй байх таамаглалыг шалгах тест нь  $\beta_{3s} = 0$  (богино хугацаанд) болон  $ec_{t-1}$  -ийн оронд Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг шууд үнэлгээд ашиглаж буй тохиолдолд  $\beta_2 = 0$  (урт хугацаанд), харин Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг үндсэн тэгшитгэлд орлуулан үнэлгээг хийж буй тохиолдолд  $\delta/\beta_2 = 0$  (урт хугацаанд) гэж шалгана. Харин үнэ нь цалингийн Гранжер шалтгаан болохгүй байх таамаглалыг шалгах тест нь  $\lambda_{3s} = 0$  (богино хугацаанд) болон  $ec_{t-1}$  -ийн оронд Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг шууд үнэлгээд ашиглаж буй тохиолдолд  $\lambda_2 = 0$ , Коинтегрэйн тэгшитгэлийн үлдэгдлийг үндсэн тэгшитгэлд орлуулан үнэлгээг хийж буй тохиолдолд  $\gamma/\lambda_2 = 0$  (урт хугацаанд) байна.

#### IV. ЭМПИРИК СУДАЛГААНЫ ХЭСЭГ

##### 4.1 Судалгаанд ашигласан тоон үзүүлэлтүүдийн тайлбар

Энэхүү судалгаандаа 1993 оны нэгдүгээр улирлаас 2005 оны 4 дүгээр улирлын хоорондын мэдээллийг ҮСГ-аас улирал бүр тогтмол хийгддэг "Өрхийн орлого, зарлагын түүвэр судалгаа"-ны мэдээлэл болон Монголбанкны МБСГ-аас эмхтгэн гаргадаг тоон үзүүлэлтүүдийг ашигласан. Тэгшитгэлүүд болон хамаарлын эконометрик үнэлгээ, шинжилгээг хийхдээ эконометрикийн Eviews 5.1 програм ашиглан гүйцэтгэлээ. Үнэлгээнд тэгшитгэлийн хэлбэрийг лог-лог функцийн хэлбэрээр үнэлгээнд оруулсан.

Эконометрик үнэлгээ, шинжилгээнд CPI: хэрэглээний үнийн индекс, MСPI: Мах, махан бүтээгдэхүүний ХҮИ зэрэг хувьсагчдыг хувиар, M1: M1 мөнгө эдгээр үзүүлэлтийг Монголбанкны тоон мэдээллээс авч ашигласан. Харин IP: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, 1995 оны зэрэгцүүлэх үнээр, GAP\_IP: Бодит болон потенциал аж үйлдвэрийн бүтээгдэхүүний зөрүү (Онолын хэсэгт ДНБ-ны зөрүү байдлаар тодорхойлогдсон хэдий ч манай орны хувьд ДНБ-ний өгөгдөл нь тогтмол улирлаар хэвлэгддэггүй тул үүний оронд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн (АҮБ)-ийг авсан, АҮБ-ний зөрүүг статистикийн хувьд тооцох боломжтой арга болох Eviews програмын Hodric-Prescott-ын аргаар тооцсон) зэрэг үзүүлэлтүүд сая төгрөгөөр, wage: улирлын өрхийн дундаж цалингийн орлого, income: улирлын өрхийн дундаж нийт орлого зэрэг үзүүлэлтүүд (эдгээр үзүүлэлтийг ҮСГ-ын тоон мэдээллээс авч ашигласан)-ийг төгрөгөөр түүвэрлэн үнэлгээнд бүх хувьсагчдыг натурал логарифм авч оруулсан. @seas(k)- к улирлын нөлөөллийг илэрхийлэх дамми хувьсагч, D,Q(i)- Бүтцийн өөрчлөлт болон цалингийн огцом өсөлтийг засварлах дамми хувьсагч болно.

##### 4.2 Нэгж язгуур болон Коинтегрэйн шинжилгээ

Судалгаанд ашиглаж буй тоон үзүүлэлтүүдийн тогтвортой эсэхийг ADF тестээр шалгаж, тестийн үр дүнг Хавсралт 2-т харууллаа. Тестийн үр дүнгээс харахад  $\log(cpi)$ ,  $\log(m1)$ ,  $\log(mcpi)$  зэрэг үзүүлэлтүүд нь 10%-ийн ач холбогдлын түвшинд ч тогтворгүй байна,

харин  $\log(\text{wage})$  3%-ийн ач холбогдлын түвшинд,  $\log(\text{income})$  7%-ийн ач холбогдлын түвшинд тогтвортой байж болохоор байгаа хэдий ч интэгрэйн зэргийг 1%-ийн ач холбогдлын түвшинд сонгосон тул тогтворгүй байна. Эдгээр үзүүлэлтүүдээс 1-р эрэмбийн ялгавар авч шалгахад бүгд 1%-ийн ач холбогдлын түвшинд I(1) процесс байна. Харин  $\text{GAP\_IP}$  нь ялгавар байдлаар тодорхойлогддог хувьсагч тул 1%-ийн ач холбогдлын түвшинд тогтвортой гэсэн үр дүн харуулж байна. Иймд энэхүү хувьсагч нь алдаа залруулах загварт оруулахдаа энгийн хэлбэрт оруулна.

Тогтворгүй үзүүлэлтүүд нь адил эрэмбийн дараа интеграцид орж байгаа буюу I(1) процесс байгаа тул эдгээр инфляци, цалин болон инфляци, орлогын хооронд урт хугацааны шугаман хамаарал (коинтэгрэйн) байгаа эсэхийг Johansen-ны аргаар шалгасан. Ийнхүү шалгахын тулд коинтэгрэйн хамаарлын хугацааны хоцролтыг тодорхойлох шаардлагатай (Johansen тест нь хугацааны хоцрогдлоос ихээхэн мэдрэмжтэй) бөгөөд хоцролтыг тодорхойлохдоо манай судалгааны түүврийн тоо харьцангуй бага тул вектор авторегресс (VAR)-ийн хоцролтыг 1-ээс эхлэн хоцролтыг нэмэх байдлаар үнэлж, үнэлгээний үлдэгдэлд диагностик тестүүдийг шалган, бусад үнэлгээнүүдээсээ илүү сайн үр дүн харуулж байгаа үнэлгээний хоцролтыг сонгосон. Коинтэгрэйн хамаарлын хоцролтын тоо нь вектор авторегресс (VAR)-ийн хоцролтоос 1-ээр бага байдаг (учир нь коинтэгрэйн хамаарлыг шалгах VEC загвар нь VAR загварын 2 талын гишүүн бүрээс 1-р эрэмбийн ялгавар авч тодорхойлдог тул хоцролт нь 1-ээр бага байна).  $\{\log(\text{CPI}), \log(\text{wage})\}$  хоорондын хамаарал нь VAR(2) загвараар,  $\{\log(\text{CPI}), \log(\text{income})\}$  хоорондын хамаарал нь VAR(3) загвараар үнэлэгдэхэд үлдэгдэлүүд нь диагностик тестийг хангаж байна (тестийн үр дүнг Хавсралт 3-аас харна уу). Иймд эдгээр хамаарлуудын коинтэгрэйн хамаарлыг шалгахдаа хоцролтын тоог харгалзан 1 болон 2-оор сонгосон болно.

Мөн коинтэгрэйн хамаарлыг шалгахдаа детерминистик трендын таамаглал тавьдаг бөгөөд өөрийн судалгааны хувьд ихэнх макро хувьсагчид ямар нэгэн тренд ажиглагддаг тул шугаман детерминистик трендтэй гэсэн таамаглал доор тестийг шалгасан болно. Тестийн үр дүнг Хүснэгт 2-т (дэлгэрэнгүйг Хавсралт 3.1-г) харууллаа.

## Хүснэгт 2. Коинтэгрэйн хамаарал<sup>#</sup>

$H_0$ эсрэгээр $H_1$	$\lambda_{\max-eigen}$ тест		$\lambda_{trace}$ тест	
	Max-Eigen Статистик	Критик утга (5%-н ач холбогдлын түвшинд)	Trace Статистик	Критик утга (5%-н ач холбогдлын түвшинд)
	$\log(\text{CPI}), \log(\text{wage})$			
$r = 0$ эсрэгээр $r = 1$	29.81*	14.26	32.48*	15.49
$r \leq 1$ эсрэгээр $r = 2$	2.68	3.84	2.68	3.84
	$\log(\text{CPI}), \log(\text{income})$			
$r = 0$ эсрэгээр $r = 1$	22.36*	14.26	25.32*	15.49
$r \leq 1$ эсрэгээр $r = 2$	2.95	3.84	2.95	3.84

<sup>#</sup>- Хугацааны хоцрогдлын уртыг  $\{\log(\text{CPI}), \log(\text{wage})\}$  хамаарлын хувьд 1-ээр, харин  $\{\log(\text{CPI}), \log(\text{income})\}$  хамаарлын хувьд 2-оор сонгож, шугаман детерминистик трендтэй гэсэн таамаглал доор тестийг шалгасан болно.

\*- 5%-ийн ач холбогдлын түвшинд  $H_0$  таамаглалыг няцааж байгааг илэрхийлэх буюу Max-Eigen болон Trace статистикууд 5 %-ийн ач холбогдлын түвшинд 2 коинтэгрэшн хамаарал байгааг харуулж байна.

Хүснэгт 2-т гарсан үр дүн нь ХҮИ, цалин, бусад нөлөөлөгч хүчин зүйлсийн хооронд, мөн ХҮИ, орлого, бусад нөлөөлөгч хүчин зүйлсийн хооронд урт хугацааны 1 боломжит коинтэгшрэн хамаарал оршин байгааг 5%-ийн ач холбогдлын түвшинд харуулж байна. Эдгээр урт хугацааны коинтэгрэшн хамаарлын коэффициент векторуудад тэмдэг нь эдийн засгийн утгатайгаа нийцтэй, статистикийн хувьд ач холбогдолтой байх векторыг тодорхойлох зорилгоор хязгаарлалт тавьж урт хугацааны коинтэгшрэн хамаарлын коэффициентүүдийг тодорхойлсон бөгөөд үр дүнг Хүснэгт 3-т харууллаа (Коинтэгрэшн векторын боломжит болон хязгаарлалт тавьсны дараахь коэффициентүүдийг Хавсралт 3-т харуулсан).

### Хүснэгт 3. Коинтэгрэшн векторууд\*

---

ХҮИ, цалингийн хоорондын урт хугацааны хамаарлын тэгшитгэл:

$$\log(CPI) = 0.07 + 0.445 \log(wage)$$

$$s.e \rightarrow (0.08)$$

$$t \rightarrow [5.44]$$

буюу

$$\log(wage) = -0.16 + 2.247 \log(CPI)$$

$$s.e \rightarrow (0.20)$$

$$t \rightarrow [11.0]$$

ХҮИ, орлогын хоорондын урт хугацааны хамаарлын тэгшитгэл:

$$\log(CPI) = 3.00 + 0.169 \log(income)$$

$$s.e \rightarrow (0.10)$$

$$t \rightarrow [1.69]$$

буюу

$$\log(income) = -17.80 + 5.913 \log(CPI)$$

$$s.e \rightarrow (0.92)$$

$$t \rightarrow [6.41]$$

---

\*- Хаалтанд байгаа тоонууд нь стандарт алдааг илэрхийлнэ.

Урт хугацааны хамаарлын үр дүнгээс харахад урт хугацаан дахь 1%-ийн цалингийн өсөлт нь 0.445 %-ийн инфляцийг бий болгодог бол харин инфляци 1% өсөх нь урт хугацаанд цалинг 2.247 хувиар өсгөдөг байна. Инфляци болон цалингийн хооронд урт хугацааны энэхүү хамаарлыг статистикийн хувьд хүлээж авах боломжтой байна. Үүнтэй адилаар өрхийн орлого, инфляцийн хоорондын урт хугацааны хамаарлыг шалгахад өрхийн орлого 1% өсөх нь инфляцийг 0.169 %-иар өсгөхөөр байгаа хэдий ч энэхүү

хамаарлын статистик ач холбогдол сул байна. Харин 1%-ийн инфляци нь өрхийн улирлын орлогыг 5.913 %-аар өсөлтийг даллахаар байгаа бөгөөд энэхүү урт хугацааны хамаарал нь статистикийн ач холбогдолтой байна.

